



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2026 он

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ТАЙЛАН
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026.02.10

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Төрийн захиргааны удирдлагын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 86.4 %-тай байна.

*Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны үйл
ажиллагааны ерөнхий дүн*

Д/д	Үзүүлэлт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт /Хувиар/	Жингийн үнэлгээ
1.	Бодлогын үр дүн	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;	-	-
2.		Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт;	-	-
3.		ТЗУГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;	53	95.0
4.	Чиг үргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;	115	94.1
5.		Сайдын тушаалын хэрэгжилт;	48	83.3
6.		Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт;	91	97.7
7.	Чадамжийн үнэлгээ	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ;	5	89.4

8.		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт;	12	50.0	-
9.		Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт;	-	-	-
10.		Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт;	-	-	-
11.		Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;	-	-	-
12.		Байгууллагын ажилтан албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт.	7	95.7	-
Нийт			331	86.4	88.2

2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
53	50	3	-	-	95.0

Хэрэгжилт хангалтгүй 3 арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	хугацаа	Биелэлт	хувь
1.	1.1.2 Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан зохион байгуулна.	Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг 24 удаа зохион байгуулж, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллана;	I-IV улирал	Тайлант хугацаанд Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг 2025.01.31, 2025.01.02, 2025.02.20, 2025.03.30, 2025.05.10, 2025.06.20, 2025.10.16, 2025.10.30, 2025.11.24, 2025.12.15-ны өдрүүдэд тус тус 10 удаа зохион байгуулж, биелэлтийг тухай бүр удирдлагуудад тайлагнасан.	50
2.	2.1.7 Зам, тээврийн яамнаас хэрэгжүүлж буй Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкны	Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт банкны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон	I-IV улирал	Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулах үүрэг бүхий дараах ажлын хэсгийг ТНБД-	50

	<p>хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулна.</p>	<p>шалгаруулалтыг 8-аас доошгүй удаа зохион байгуулна;</p>		<p>ын тушаалаар байгуулаад байна. Үүнд: 1.Азийн хөгжлийн банкны төслийн нэгж-Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/160 дугаар тушаал 2.Дэлхийн банкны төслийн нэгж-ТНБД-ын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/101дугаар тушаал 3.Европын сэргээн босголь хөгжлийн банкны төслийн нэгж-ТНБД-ын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/100 дугаар тушаал 4.Азийн хөгжлийн банкны Бүс нутгийн авто замын арчлалт төслийн нэгж-ТНБД-ын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/96 дугаар тушаал тус тус батлуулж, сонгон шалгаруулалт зарлах нөхцөлийг бүрдүүлээд байна. Сонгон шалгаруулалтаар шалгарсан нэр дэвшигчдийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/92 дугаар тушаал, Б/96 дугаар тушаал, Б/97 дугаар тушаал, Б/99 дүгээр, Б/104 дугаар тушаал, Б/105 дугаар тушаалаар тус тус томилсон.</p>	
3.	<p>Албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч, цэвэр агаарт амрах, биеэ сувилуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.</p>	<p>“УБТЗ” ХНН-ийн Баянбуурал, “ИНҮТ” ТӨХХК-ийн харьяа Жаргалт амралтын газруудын тохижилтод анхаарч хамтран ажиллана. Албан хаагчдын саналыг харгалзан хуваарийг батлуулан холбогдох байгууллагад хүргүүлнэ.</p>	I-IV улирал	<p>1.Төрийн захиргааны удирдлагын газраас албан хаагчдын хүсэлтийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны үзэсгэлэнт газраар аялах арга хэмжээг зохион байгуулсан. 2.Төрийн захиргааны удирдлагын газраас албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч цэвэр агаарт гарах арга хэмжээг 2025 оны 09 дугаар сарын 19-ний өдөр Дорноговь аймагт зохион байгуулав.</p>	50

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
115	100	9	2	2	1	94.1

Хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээ:

Тушаал, шийдвэр: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 дугаар 2024_39.

Заалтын агуулга:

39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав;

(Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.2.Ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.3.Нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.4.Хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.5.Хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.6.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.7.Энэ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр биелэлт ирүүлэх;

Биелэлт: Зам, тээврийн салбарын улсын бүртгэлтэй 65 захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Шийдвэр хүчингүй болгох тухай" 192 дугаар захирамжаар "Дүрэм батлах тухай" Дэд бүтцийн сайдын 2002 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 261 дүгээр тушаал, "Дүрэм батлах тухай" Зам тээвэр, барилга, байгуулалтын сайдын 2010 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 111 дүгээр тушаал, "Дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 211 дүгээр тушаалуудыг тус тус хүчингүй болгосон.

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
48	37	6	5	-	-	83.3

Хэрэгжээгүй 5 арга хэмжээ:

Тушаал шийдвэр: Ажлын хэсэг байгуулах тухай 2023.04.24 А/127;

Заалтын агуулга: Зам, тээврийн салбарын албан хаагчдын орон сууцны хотхон байгуулах ерөнхий төлөвлөгөө болон ажлын зураг боловсруулах төлөвлөгөөг батлуулах, ерөнхий төлөвлөгөөний дагуу хотхон байгуулах гүйцэтгэгчийг хууль, тогтоомжийн хүрээнд яаралтай сонгон шалгаруулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Одхүү)-д НБД А.Оюунболд Ж.Оюунжаргал;

Биелэлт: Ажлын хэсгийн хуралдааныг 2023.05.01-ний өдөр зохион байгуулсан. Хотхон байгуулах урьдчилсан ерөнхий төлөвлөлтийг боловсруулсан. Зам, тээврийн салбарын албан хаагчдаас хотхонд хамрагдах албан хаагчдын судалгаа авсан. Хот байгуулалт хөгжлийн газарт архитектур төлөвлөлтийн даалгавар авах албан бичиг хүргүүлсэн боловч газрын зориулалтыг өөрчлөх шаардлага тавьсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг бүрдүүлсэн. Хэрхэн сонгон шалгаруулах талаар удирдлагаас чиглэл хүлээж байна.

Тушаал шийдвэр: Улсын чанартай авто замын дагууд 2022 онд хийгдсэн амрах талбайн үлдэгдэл ажил болон төсвийн зөрүүд зарцуулах хөрөнгийн жагсаалт батлах тухай 2023.08.10 А/219;

Заалтын агуулга: Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын 2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан "Олон улс, улсын чанартай авто замын дагуу зогсоол байгуулах, 2022 оны үлдэгдэл санхүүжилт" зардлаас санхүүжих "Улсын чанартай авто замын дагууд 2022 онд хийгдсэн амрах талбайн үлдэгдэл ажил болон төсвийн зөрүүд зарцуулах хөрөнгийн жагсаалт"-ын дагуу 1,458,099,608 (Нэг тэрбум дөрвөн зуун тавин найман сая ерэн есөн мянга зургаан зуун найм) төгрөгөөр амрах талбайн үлдэгдэл ажил болон төсвийн зөрүүг зам хариуцагч компаниудтай гэрээ байгуулан санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (С.Батболд)-д зөвшөөрсүгэй;

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/219 дүгээр тушаалаар "Улсын чанартай авто замын дагууд 2022 онд хийгдсэн амрах талбайн үлдэгдэл ажил болон төсвийн зөрүүд зарцуулах хөрөнгийн жагсаалт"-ын дагуу 1 458 099 608 (Нэг тэрбум дөрвөн зуун тавин найман сая ерэн есөн мянга зургаан зуун найм) төгрөгийн гэрээг зам хариуцагч компаниудтай байгуулаад байна. Амрах талбайн үлдэгдэл ажил болон төсвийн зөрүүний гүйцэтгэлийг Зам, тээврийн хөгжлийн төв, АЗБЗГ-аас хянаж ирүүлээгүй байна.

Тушаал шийдвэр: Хөтөлбөр батлах тухай 2023.12.04 А/303;

Заалтын агуулга: "Зам, тээврийн салбарын албан хаагчдын орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Ц.Одхүү)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т

Биелэлт: Хяналт тавин ажиллаж байна.

Тушаал шийдвэр: Жагсаалт батлах тухай 2025.02.14 А/44;

Заалтын агуулга: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын Зам, тээврийн сайдын төсвийн XV.2.4.1-д заасан "Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник; эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл)" төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх

ажлын жагсаалт, 2025 онд санхүүжүүлэх дүн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж ажиллахыг төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт), Автозамын бодлого зохицуулалтын газар (Г.Батбаяр), санхүүжилтийг баталсан дүнд багтаан санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс (Т.Сумъяа)-т нарт;

Биелэлт: “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник; эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл)” төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын тендерийг зарлаж, үнэлсэн боловч амжилтгүй болсноор дахин зарласан ч мөн адил амжилтгүй болоод байна. (хяналтаас хасах)

Тушаал шийдвэр: Ажлын хэсэг байгуулах тухай 2025.03.25 А/82 АХД С.Батболд НБД Б.Болор-Эрдэнэ;

Заалтын агуулга: Засгийн газраас “2025 оныг Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан XV. 1.4.6 “Хөшигийн хөндий туннел” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/, XV.2.4.1 “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл/, XV. 1.4.7 Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт, шуурхай удирдлагаар хангах, төсөл арга хэмжээг хуульд нийцүүлэн зохион байгуулж төслийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж, явц үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж танилцуулахыг Ажлын хэсэг (С.Батболд)-т

Биелэлт: 2024 оны 12 дугаар сарын 25 өдөр Зам тээврийн яам Хөшигийн хөндий туннел болон Өөдөө тэмүүлэх Монгол ган татлага бүхий гүүрэн байгууламжийн Техник эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөл боловсруулах олон улсын нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг зарласан бөгөөд энэ хүрээнд БНХАУ-ын Чайна дизайн компани шалгаран тус яамтай гэрээ байгуулан техник эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. 2025 оны 03-р сарын 17-ны өдөр Зам тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн өргөтгөсөн зөвлөлөөр тус төслийн трассыг сонголтын хэлэлцүүлэн гүйцэтгэгч байгууллагад зөвлөмжийг хүргүүлсэн байна. Мөн тус төслийн хүрээнд Богд хан уул орчимд инженер геологийн судалгаа хийх ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. /Хэрэгжилтийг хасах саналтай/ (хяналтаас хасах)

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
91	87	2	1	1	-	97.78

Тушаал шийдвэр: Гадаад улсад томилолтоор ажиллуулах тухай 2025.03.19 А/62;

Заалтын агуулга: Зам, тээврийн сайдыг Япон Улсын Гадаад хэргийн яамны урилгаар Япон Улсын Токио хотноо Сайд нарт зориулсан айлчлалын хөтөлбөр буюу Практик түвшний стратегийн солилцооны хөтөлбөрт хамрагдахад дагалдан явах

зорилгоор тус М.Энхболд, Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Нямдаваа, Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан Ш.Олонбат, Олон нийттэй харилцах ажилтан Г.Жаргалмаа нарыг 2025 оны 03 дугаар сарын 25-30-ны өдрүүдэд Япон Улсад томилолтоор ажилласан тухай тайланг холбогдох журмын дагуу танилцуулахыг Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Нямдаваад;

Биелэлт: Тушаал гарсан ч удирдлагын зүгээс яваагүй хойшилсон. (хяналтаас хасах)

2.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

Тайлант оны жилийн эцсийн байдлаар Төрийн захиргааны удирдлагын газрын нээлттэй мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг бүлэг тус бүрээр харуулбал. Үүнд:

Д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал;	87.1
2.	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал;	90.0
3.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал;	70.0-5
4.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал;	100-13
5.	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал.	100
Нийт дундаж		89.5

Тайлант оны жилийн эцсийн байдлаар Төрийн захиргааны удирдлагын газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 70-100 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн 20 арга хэмжээг дурдвал:

2.6. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	
12	12	6	6	-	50.0

2.7. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад эрх бүхий байгууллагаас 2025 онд хийсэн хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн бөгөөд энэхүү үнэлгээг хяналт-шинжилгээ үнэлгээний тайланд тусгаагүй болно.

Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Эрх бүхий байгууллага	Зөвлөмжийн агуулга	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
			Нийт	Үүнээс		
				Хэрэгжсэн	Идэвхгүй	
1.	ҮАГ	Зам, тээврийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /Яамны аппарат/;	21	9	12	43%
2.	ҮАГ	Зам, тээврийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /Төсвийн ерөнхийлөн захирагч/;	12	3	9	25%
3.	ҮАГ	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт;	3	3	0	100
4.	ЗТЯ	Зам, тээврийн яамны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт;	14	2	12	14%
5.	ЗТЯ	Зам, тээврийн яамны төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.	9	9	0	0%
Нийт			59	26	33	36.4

Зам, тээврийн салбарын хэмжээнд Үндэсний аудитын газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хяналт-шинжилгээ үнэлгээ болон хяналт, шалгалтын “зөвлөмж”-ийн хэрэгжилтийг үнэлж, яам, дотоод нэгж болон харьяа байгууллагын үйл ажиллагааны тайланд үнэлгээний дүнг тусгаж ажиллана;

ТЗУГ нь 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 2025-01 дугаартай удирдамжийн хүрээнд хийсэн “Зам, тээврийн яамны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа”-нд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт 14%-тай, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Зам, тээврийн сайдын баталсан “Зам, тээврийн яамны төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлтэд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 0 хувьтай байгаа тул цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

3.1.Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 86.4 %-тай байна.

3.2.Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 53 арга хэмжээний хэрэгжилт 95 хувьтай байна. Үүнээс 95 хувь нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 5 хувь нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна. Үүнд:

- ✓ Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг 24 удаа зохион байгуулж, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллана
- ✓ Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт банкны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулалтыг 8-аас доошгүй удаа зохион байгуулна
- ✓ “УБТЗ” ХНН-ийн “Баян буурал”, “ИНҮТ” ТӨХХК-ийн харьяа “Жаргалт” амралтын газруудын тохижилтод анхаарч хамтран ажиллана, гэсэн арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

3.3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл

Зорилт	Арга хамжээ	Хэрэгжилтийн хувь
1. Яамны дотоод үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг хангах, удирдлагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	7	81.4
2. Яамны үйл ажиллагааг хэвийн жигд, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангана.	7	100
3. Яамны аппаратыг мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр бүрдүүлж, оновчтой, зөв байршуулах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангана.	14	92.8
4.Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, салбарын боловсон хүчин бэлтгэх, сургалт, урамшууллын оновчтой тогтолцоог нэвтрүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	7	100
5.Яамны үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулна.	2	100
6.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн болон байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах ажлыг хариуцан зохион байгуулна.	3	100
7.Яамны төрийн нууцад хамаарах баримт бичгийн бүртгэл, танилцуулга, шилжилт, хадгалалт нууцлалтад хяналт тавьж, холбогдох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.	2	100
8.Салбарын хэмжээнд эрх зүйн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангана.	3	90
9.Яамны удирдлага болон бусад газар, хэлтэст хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.	8	100
Нийт 9 зорилт арга хэмжээний дундаж нь 95 хувьтай байна.	53	95

Дөрөв. Санал, зөвлөмж

Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны үйл ажиллагааны тайланд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ хийж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжилт хангалтгүй байгаа дараах арга хэмжээг зорилтот түвшинд хүргэн ажиллах;

2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар, улирал, хагас болон бүтэн жилийн байдлаар бүрэн хангаж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тайланг тогтмол хугацаанд төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлж хэвшихийг яамны газар, нэгжүүдэд;

3. Сайдын тушаалын хэрэгжилтийг улирал тутам яамны газруудаас авч нэгтгэн, бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулж, үр дүнгийн нэгдсэн тайлан боловсруулж танилцуулахыг холбогдох газар, нэгжүүдэд;

4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулан, албан хаагчдын гадаад, дотоод томилолтын тайланг холбогдох журамд заасан хугацаа, шаардлагын дагуу бүрэн гүйцэд тайлагнахыг холбогдох газар, нэгжүүдэд;

5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, Засгийн газрын 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг тогтмол хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулах;

6. Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан журмын зургаадугаар хавсралтаар баталсан "Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмж"-д тусгагдсан Яамны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлангийн хэрэгжилт 14 хувьтай, мөн Яамны төрийн алба хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан 0 хувьтай арга хэмжээг бүрэн гүйцэд тайлагнах;

7. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмж"-ийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн тайлагнаж хэвшихийг Яамны газар, хэлтэст;

8. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх зардлыг тооцон, төсөвт тусган батлуулж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, үр дүнг нийт албан хаагчдад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөрт багтаан тайлагнаж, 2027 оноос шинээр хэрэгжих хөтөлбөрийн төслийг боловсруулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

9. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө бүрэн тусгаж, төлөвлөлтийг зөв тодорхойлон, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

